**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/24 Чойр

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баярын өдрүүд 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрийг дуусталх хугацаанд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг 1 дүгээр, аж ахуй нэгж, албан байгууллага, хариуцлагатай жижүүрийн гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Аймгийн нутаг дэвсгэрт болзошгүй гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хангах ажлыг зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа (Ц.Баярхүү), Гамшгаас хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Х.Сүхбаатар), Яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (У.Ариун-Эрдэнэ), энэхүү захирамжийн 2 дугаар хавсралтад заагдсан үүргийг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга нарт болон Хариуцлагатай жижүүрийн үүрэгт ажлыг гүйцэтгэж байгаа албан хаагч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31 –ны өдрийн А/24 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

| № | Байгууллага | Овог. нэр | Утас | Огноо | Цагийн хуваарь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга | Н.Алтанцэцэг | 99043498 | 2022.02.02 | 08:00-10:00 |
| 2 | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга | Ц.Оюунбилэг | 95800101 | | 10:00-12:00 |
| 3 | Боржигин өв музейн дарга | А.Ундармаа | 99014021 | | 12:00-14:00 |
| 4 | Боржигин чуулгын дарга | Ц.Цэнджав | 91910734 | | 14:00-16:00 |
| 5 | Статистикийн хэлтсийн дарга | Л.Мөнгөнцэцэг | 99549900 | | 16:00-18:00 |
| 6 | Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ-ын дарга | Ц.Энхжаргал | 99101459 | | 18:00-20:00 |
| 7 | Авто тээврийн Төвийн дарга | Н.Мөнхнаран | 99199390 | | 20:00-22:00 |
| 8 | Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга | Д.Мөнх-Эрдэнэ | 99087636 | | 22:00-24:00 |
| 9 | 1-р сургуулийн захирал | Г.Сонинбат | 99046945 | 2022.02.03 | 08:00-10:00 |
| 10 | ХХАА-н газрын дарга | Н.Даваахүү | 99024828 | | 10:00-12:00 |
| 11 | Татварын хэлтсийн дарга | П.Энх-Оюун | 91115702 | | 12:00-14:00 |
| 12 | 5-р сургуулийн захирал | О.Одгэрэл | 99549154 | | 14:00-16:00 |
| 13 | 1-р цэцэрлэгийн эрхлэгч | С.Туяагэрэл | 99549414 | | 16:00-18:00 |
| 14 | 6-р цэцэрлэгийн эрхлэгч | Б.Болормаа | 99549905 | | 18:00-20:00 |
| 15 | Нийгмийн даатгалын хэлтсийн дарга | Б.Аюушжав | 99908461 | | 20:00-22:00 |
| 16 | 2-р сургуулийн захирал | О.Базарбаатар | 86059995 | | 22:00-24:00 |
| 17 | ХХҮ-ний газрын дарга | Х.Буянбаяр | 99549478 | 2022.02.04 | 08:00-10:00 |
| 18 | Номын сан | Д.Нарнай | 99549086 | | 10:00-12:00 |
| 19 | БТС-ын газрын дарга | Б.Буянтогтох | 94114420 | | 12:00-14:00 |
| 20 | ГХБХБ-ын газрын дарга | Б.Отгончимэг | 99665607 | | 14:00-16:00 |
| 21 | БШУ-ний Газрын дарга | А.Зургаанжин | 99079355 | | 16:00-18:00 |
| 22 | Мэргэжлийн хяналтын газар | Б.Ганбаяр | 99121764 | | 18:00-20:00 |
| 23 | СУГ-ын дарга | Б.Энхтөр | 99993422 | | 20:00-22:00 |
| 24 | Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийн захирал | Ш.Отгонжаргал | 91924441 | | 22:00-24:00 |

Аймгийн Засаг даргын 2022 оны 01
дүгээр сарын 31 –ны өдрийн А/24 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР ХИЙХ БАЙГУУЛЛАГА,**
**АЖ АХУЙ НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

1. Томилогдсон хариуцлагатай жижүүрүүд 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 04-ний өдрүүдэд 08:00-аас 24:00 цагийн хооронд тасралтгүй ажиллаж, аймгийн хэмжээний мэдээг 3 цаг тутамд холбогдох байгууллагуудаас авч, шаардлагатай үйл ажиллагаатай биечлэн танилцаж, үүрэг, чиглэл, зөвлөмж өгч, биелэлтийг тооцно.
2. Сумдын Засаг даргын Тамгын газар болон бусад төрийн байгууллагууд хариуцлагатай жижүүр томилон баярын өдрүүдэд гэнэтийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлж, мэдээ мэдээлэл солилцож, шаардлагатай үед түргэн, шуурхай арга хэмжээ авч ажиллана.
3. Ус, дулаан, цахилгаанаар хангагч байгууллагууд хариуцлагатай жижүүр томилон, баярын өдрүүдэд осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж ажиллах бөгөөд аймаг, сумдын хариуцлагатай жижүүрт мэдээг 3 цаг тутамд өгч, гэмтэл, осол гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллана.
4. Ус-Ду ОНӨААТҮГазар хэрэглээний халуун усаар тогтмол хангаж, СӨХ-ийн үйл ажиллагааг удирдлагаар ханган, орцны гэрэлтүүлэг, шугам сүлжээ, халаалтын найдвартай байдлыг хангаж ажиллана.
5. Төрийн байгууллагууд, ус, дулаан, цахилгаанаар хангагч байгууллагууд холбоо барих суурин утасны байнгын ажиллагааг хангаж, хариуцлагатай жижүүрийг мэдээ, мэдээллээр хангана.
6. Сумдын Засаг дарга нар худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавина.
7. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ гудамж талбайн гэрэлтүүлгийн ажиллагааг бүрэн хангаж, хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэнэ.
8. Холбооны газар нь холбоо мэдээлэл, кабелийн шугамын хэвийн, найдвартай байдлыг хангаж, эвдлэр гэмтэл гарсан тохиолдолд засвар, үйлчилгээг түргэн шуурхай авч хэрэгжүүлнэ.
9. Дээрх байгууллагууд заагдсан үүргийг чанартай гүйцэтгэж, тайланг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.
10. Жижүүрийн ажлыг хариуцлагагүй гүйцэтгэсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцох бөгөөд дараагийн жижүүрт ажлаа хүлээлцэхдээ албан ёсоор илтгэх хуудас бичиж, гарын үсэг зуруулж, өөрийн биеэр хүлээлцэнэ.
11. Хариуцлагатай жижүүр нь аймгийн Засаг даргын Тамгын газрын 70543163 дугаарын утсаар мэдээллийг авч, түргэн, шуурхай холбогдох арга хэмжээг авна.
12. Шаардлагатай утасны дугаар:

| № | Байгууллага | Утасны дугаар |
|---|---|---|
| 1 | Засаг даргын орлогч Б.Анхбаяр | 99014302 |
| 2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном | 99549014 |
| 3 | Аймгийн Засаг даргын Тамгын газар /жижүүр/ | 70543163 |
| 4 | Онцгой байдлын газар /жижүүр/ | 7054101, 70541109 |
| 5 | Цагдаагийн хэлтэс /жижүүр/ | 7054102 |
| 6 | Эмнэлэг /түргэн тусламж/ | 7054103 |
| 7 | [illegible] | [illegible] |